

ДеФакто **ТОЙМ**

АХБ ЭКО ХОРООЛЛЫГ
ДЭМЖИНЭ

340 МЯНГАН ТОНН
НҮҮРС ХААЧИВ?

БНХАУ-ЫН ГАДААД ХЭРГИЙН
САЙДЫН АЙЛЧЛАЛ

IV НҮҮРТ

ДеФакто **НИЙТЛЭЛ**

Д.Жаргалсайхан
Эдийн засагч, нийтлэлч

Итгэлийн ХЯМРАЛ

II НҮҮРТ

The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ | ЗОРИГЖУУЛНА | МЭДЭЛЖҮҮЛНЭ

Лхагва, 2018.09.05, №62

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ, БИЕ ДААСАН, УЛС ТӨРИЙН
НАМААС ХАРААТ БУС ДОЛОО ХОНОГ ТУТМЫН СОНИН

www.defacto.mn



Дамбадаржаагийн **ЖАРГАЛСАЙХАН**Долоо хоног бүрийн нийтлэл,
<http://jargaldefacto.com/category/23>

Итгэлийн ХЯМРАЛ

Монголд эдүгээ эдийн засгийн хямралаас гадна, итгэлийн хямрал нүүрлээд байна.

Эдийн засгийн хямралд иргэд бид бүр дасчихжээ. Төгрөг сулраад, үнэ нэмэгдээд, төсвийн алдагдал ихсээд, төр нь гадна дотны зах зээлээс хаадынхаа нэрийг барьж бондын зээл аваад л. Төр зээлийнхээ өрөнд баригдаад, хүүгээ ч төлж дийлэхгүй болоод ирэхээр, ОУВС хямд зээл өгч гал алдчихгүй, хөлдөж үхчихгүй хавартай золгоод л. Гадаадаас зээл тусламж авснаа гавьяа байгуулсан мэтээр улс төрчид сурталчлаад л ..., өрөвдөлтэй. Тэгээд нүүрс, зэсийн үнийн мөчлөг өгсүүр талдаа гармагц төсвийн орлого нэмэгдэж, төрийн ажилтнуудын цалинг нэмээд л. Хувийн хэвшил нь тэгж чадахгүй болохоор ажиллагсад нь гадагшаа гарч, голдуу Солонгост ажиллахыг илүүд үзээд л.

АТГ БА БОАЖ-ЫН САЙДЫН ХЭН НЬ ҮНЭН ЯРЬЖ БАЙНА ВЭ?

2018 оны 8-р сарын 27-нд АТГ-аас “Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд засвар хийх, хурлын заалны тоног төхөөрөмж нийлүүлэх нийт 200 орчим сая төгрөгийн тодорхой хэсгийг ном, товхимлын мөнгө мэтээр халхавчлан тус яаманд хэрэгжиж буй төслийн мөнгөнөөс “Эрдэнэзул” ХХК руу шилжүүлж бэлэн мөнгө болгон гарган авч засварын ажлыг БОАЖ-ын сайдын хамаарал бүхий өөр компани гүйцэтгэсэн байж болзошгүй нөхцөл байдал тогтоогдсон. Холбогдох шалгалтыг үргэлжлүүлэн хийж байна” гэв.

8-р сарын 30-нд Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат “АТГ-ын мэдээллийг харсан. Албан ёсны мэдээлэл дээр нь засварыг

“*Тэгвэл сүүлийн үед онцгой мэдрэгдэх болсон нөгөө нэг хямрал бол иргэдийн итгэлийн хямрал.*”

Судлаачдын үзэж буйгаар ардчилсан нийгэмд иргэд нь төрийн болон төрийн бус байгууллагууд, бизнес, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ямар түвшинд итгэж байгаа нь улс орны хөгжилд нөлөөлнө.

Монголчуудын итгэл, юуны өмнө төрийн байгууллагуудад итгэх итгэл нь улам бүр алдагдсаар байна. Манай төрийн байгууллагуудын хүний нөөц үндсэндээ төр засгийн эрхийг сүүлийн гуч шахуу жил ээлжлэн болон эвсэн барьж ирсэн МАН болон АН-ын гишүүд дэмжигчдээс бүрддэг. Бодит байдлыг тодорхой, шинэхэн жишээн дээр харж болно.

сайдын хамаарал бүхий компани гүйцэтгэсэн байж болзошгүй гэсэн. Миний хөрөнгө орлогын мэдүүлэгт байгаа 26 компанийн нэг нь ч энэ үйл ажиллагаанд оролцоогүй гэдгийг албан ёсоор мэдэгдэж байна”. “...энэ бол улс төржсөн мэдэгдэл” гэв.

“*АТГ “болзошгүй” гэж хэлээд хэн нэгнийг буруутгадаг, сайд нь “...миний 26 компаниа холбоогүй энэ бол улс төржсөн худлаа мэдээлэл” гэснийг харахад төрийн институт, төрийн сайд хоёрын хэн нь үнэн ярьж байгаа юм бэ? гэж чангаар асуумаар байна.*”

ИХ ХУРЛЫН ГИШҮҮН, КОМПАНИ ХОЁРЫН ХЭН НЬ ҮНЭН ЯРЬЖ БАЙНА ВЭ?

2018 оны 8-р сарын 30-нд УИХ-ын гишүүн Лувсангийн Энхболд:

➤ Монголын ард түмний өмчөөс 268.3 мянган

тонн нүүрс хулгайд алдагдсан нь нотлогдлоо. Сангийн сайд Ч.Хүрэлбаатараар ахлуулсан ажлын хэсэг шалгасан. ...ГЕГ-аас эх үүсвэргүй 390 мянган тонн нүүрс Тавантолгойн ➤

- ▶ орд газраас гарсан, ...хууль хяналтын байгууллагад шилжүүлэх шийдвэр гаргасан.
- Мөн Хил хамгаалах ерөнхий газраас МУ-ын хилээр 2013-2017 оны хооронд нийт 849,121 машин гарсан гэсэн бол ГЕГ-аас 814 мянган машин гарсан гэж мэдээлжээ. 35 мянган машины зөрүү гарчээ. ... хэрвээ нүүрстэй байсан бол ... нийтдээ 3 сая тонны асуудал гарахыг үгүйсгэхгүй.
- Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас Эрдэнэс Тавантолгойгоос 340 мянган тонн нүүрс алдагдсан гэж тогтоосон. ... 25 орчим сая доллар буюу 60 орчим тэрбум төгрөгийн өмч хөрөнгө алга болсон. Энэ бол 1000 хүүхдийн 25-30 сургууль, буюу 2 ээлжээр бол 60 мянган хүүхдийн хичээлийн байр барих хөрөнгө юм.
- "... Тавантолгой Транс компани 390 мянган тонн нүүрсийг эх үүсвэргүйгээр буюу аль нэг ААН-ээс худалдаж авсан гэх санхүүгийн баримтгүйгээр хил нэвтрүүлсэн".
- Шалгах гэхээр Тавантолгой Транс компани санхүүгийн баримт бичиг үерт автсан гэдэг. Орон нутгийн өмчит Тавантолгой 6 жил уулын ажлын төлөвлөгөөгүй, байгаль орчны менежментийн нарийвчилсан төлөвлөгөө батлуулаагүй. Ашигт малтмалын газар анзаараагүй, БОАЖЯ, хянаж байх ёстой

байгууллагууд юу хийж байсан юм бэ?" гэв.

Эрхэм гишүүний энэ мэдэгдлээс харахад монголын төр засаг ажлаа хийж чадахгүй болсон, ер нь дампуурсан, аль нэг компани хаа дуртай газраа нүүрс сорчлон ухаад, нэрээ ч бичихгүй хилээр 360 мянган тонн нүүрс гаргачихсан бололтой. Гааль ба хил хамгаалах газрын тоолсон машины зөрүү нь 35-аар биш бүр 35 мянгаар зөрж байна. Хилээр ер нь юу ч ачаад гаргаж болдог гэж ойлгуулж буй учир төр засгийн институтид итгэх итгэл навс унаад байна.

2018 оны 9-р сарын 3-нд Ажнай корпорацийн охин компани, Тавантолгой транс ХХК мэдэгдэл гаргав (Орон нутгийн Тавантолгой компанийн 51 хувийг Өмнөговь аймаг, 20 хувийг Ажнай корпораци, бусдыг нь олон нийт эзэмшдэг). Уг мэдэгдэлд: 390 мянган тонн нүүрс улсын хилээр эх үүсвэргүй гаргалаа. Нүүрс хулгайлагдсан нь нотлогдлоо гэсэн ноцтой гүтгэлгийг УИХ-ын гишүүн Л.Энхболд өөрийн биеэр тараалаа... шүүхээс гэм буруутайг нь тогтоох хүртэл хэнийг ч гэмт хэрэгт буруутгаж болохгүй гэсэн хуулийн тулгуур зарчмыг эрхэм хууль тогтоогч хөсөрдүүлсэн..." гэжээ.

“*Нүүрс “гаргасан, гаргаагүйг” хэлсэнгүй, харин шүүхээр үнэнийг тогтооно гэжээ. Үнэхээр “нууцаар хил гаргасан” бол иргэдийн төрөөс гадна бизнест итгэх итгэл улам алдрах юм. Жишээ нь, компани хоёрын хэн нь үнэн ярьж буйг таашигүй.*”

ЭРГЭЦҮҮЛЭХ НЬ

Төрийн гурван засаглалын хамгийн сул дорой нь шүүх засаглал. Монголын шүүх авлигын хэдэн арван дуулиантай хэргүүдийн үнэн мөнийг одоо болтол тогтоож чадахгүй л байна. Сүржин баривчилгаанууд даржин замхарсаар л. Монголын шүүх засаглал драмын театр болж, хууль, хүчний байгууллагууд үндсэн үүргээ орхиод, дүрд тоглох ажилтай болов.

Ийм учраас төр засагт итгэх иргэдийн итгэл унасаар хямралын түвшинд очив. Эдүгээ хууль тогтоох, хэрэгжүүлэх, шүүх засаглал улс төр бизнесийн тодорхой бүлэглэлүүдэд бүрэн худалдагдаж, хуваарилагдсан.

Дээрх хоёр хэргийн аль нь үнэн болохыг монголын төр тогтоож чадахгүй, тэр ч байтугай ойлгомжтой, бодит мэдээлэл өгч чадахгүй юм.

“*Итгэлийн хямрал өнөөдөр гэнэт бий болоогүй, төр засаг авлигын сүлжээнд орж, улс төрийн намын нэрээр газар, байгалийн баялаг, нийтийн хөрөнгийг олон жил завишж, ямар ч хариуцлага хүлээдэггүй явж ирсний үр дагавар.*”

Төр засагт итгэх итгэлийг дээшлүүлэхийн тулд иргэдийн оролцоо чухал. Учир нь ардчилсан нийгэмд иргэд чөлөөт сонгуульд оролцохоос гадна төр засгийн эрх мэдлийг өгсөн төлөөлөгчөө бүрэн хянаж чадах ёстой. Иргэний нийгэм тооноос чанарт шилжих, тэгэхийн тулд хүн бүр засаг төрөө ил тод байх, ажлаа хийхийг хамтран шаардахаас өөр сонголтгүй.

2018.09.05



ДеФакто **ТОЙМ**

Ням гараг бүр VTV телевизээр 19 цагт гардаг Дефакто тоймын эмхэтгэл:
2018.09.02-ны дугаар

Долоо хоног бүрийн тойм, <http://jargaldefacto.com/category/12>

АХБ ЭКО ХОРООЛЛЫГ ДЭМЖИНЭ

Азийн хөгжлийн банк (АХБ)-ны Захирлуудын зөвлөл Улаанбаатар хотын гэр хорооллыг орлоготой нийцсэн, хилэмжийн хийн ялгарал багатай, уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах чадвартай, амьдрахад таатай эко хороолол болгон хөгжүүлэхээр 80 сая ам.долларын зээлийн төслийг баталсан. Энэ нь "Ногоон хороолол"

байгуулах нийт 570 сая ам. долларын өртөгтэй төслийн хоёрдугаар шатны санхүүжилт. Бүтээн байгуулалтын эхний шатыг гадны компаниуд хариуцна. Азийн Хөгжлийн банк, Нийслэлийн Засаг даргын тамгын газар боловсруулсан загварын дагуу эхний ээлжид жишиг барилгуудыг байгуулж, дараа нь дотоодын компаниуд төсөлд оролцох боломж бүрдэнэ гэж байгаа. Эко хорооллуудыг бий болгох энэ ажил газрыг сайн дурын цндсэн дээр орон сууцаар солих зарчимд тулгуурлан хэрэгжинэ.



Монгол Улсын нийт хүн амын гуравны нэг нь дэд бүтцийн асуудал шийдэгдээгүй, хатуу хог хаягдлын менежмент хангалтгүй, ус хангамж хязгаарлагдмал зэргээс шалтгаалсан эрүүл мэнд, байгаль орчны асуудлууд ихээр тулгардаг гэр хороололд амьдарч байгаа.

АХБ-ны санхүүжилтээр энэ хөтөлбөрийг эхлүүлж байгаа учраас засаглал нь илүү ил тод байх болов уч гэж хүлээж байна.

Энэ төслийн зорилго нь бага орлоготой, гэр хороололд амьдардаг хүмүүст зориулсан "Нийтийн аж ахуйн үйлчилгээнд холбогдсон, ногоон орчин бүрдсэн, төрөл бүрийн үйлчилгээ болон ажлын байр хүртээмжтэй, байгаль орчинд ээлтэй 20 орчим эко хорооллыг энэхүү төслөөр санхүүжүүлэх бөгөөд ингэснээр төслийн үр шимийг шууд хүртэн "ногоон" орон сууцанд орох 10,000 оршин суугчийг оролцуулаад нийт 100,000 орчим иргэний амьдрах орчин сайжирна" гэж байгаа.

Нийслэлийн орон сууцны корпорациас 2016 онд хийсэн судалгаагаар 150,000 айлын орон сууцны эрэлт байгаа хэдий ч төлбөрийн чадварт нийцсэн

орон сууцны нийлүүлэлт нь дөнгөж 4,000 айлын орон сууц байгааг, мөн гэр хорооллын хүн амын 60 хувь нь хэрэв боломжийн үнэтэй, сэтгэлд нийцэх хувилбар байвал орон сууцанд орох хүсэлтэй байгааг тогтоосон байдаг. Тэгэхээр өнөөдрийг хүртэл явуулж байгаа ипотекийн зээлийн цаана ямар эерэг болон сөрөг талууд байсныг эргэн нэг бодолцох цаг ирсэн. Гол асуудал нь шинэ байрны үнэ дэндүү өндөр, төр хөнгөлөлттэй зээл өгнө гэчихсэн учраас зах зээлийн жамаараа үнэ нь буурахгүй байгаа. Чадвартай худалдан авагчид нь авчихсан одоо чадваргүй нь үлдчихээд байна.

Анх энэ хөтөлбөрийг төр засаг борлуулагч талынх нь лоббигоор хийсэн л дээ. Тиймээс хөнгөлөлттэй зээл гэсэн нэрийн дор төсвөөс зөрцөг нь гаргаж өгөөд байгаа төсөл.

Ипотекийн зээлтэй холбоотой бас нэг чухал асуудал бол газрын эзэмших, өмчлөх, ашиглах асуудал. Эрх мэдэлтэй хүмүүс л газар аваад баяжаад байгаа явдлыг арилгахгүй бол орон сууцныхаа асуудлыг шийдэхгүй.

Монголбанк 2017 оны 9-р сард хийсэн судалгаагаар 4.2 их наяд төгрөгийн орон сууцны зээлийн үлдэгдэлтэйгээс 90 хувь нь 80 м2 хүртэлх ба түүнээс бага хэмжээтэй орон сууцнууд байгаа ба зээлийн хугацаа нь 2-оос 30 жил, жигнэсэн дундаж нь 17.9 жил, зээлийн хүү 8, банкуудын өөрийн хөрөнгийн санхүүжилтээр бол 16.9 хувийн хүүтэйгээр орон сууцны зээл олгож ирсэн байна. Бүх зээлдэгч 92.6 мянган хүн байгаагаас 65 хувь нь сарын 2 сая төгрөг хүртэлх орлоготой байсан. Бүх байр авсан хүмүүсийн 92 хувь нь нийтийн орон сууцанд амьдарч байсан, 6.3 хувь нь л гэр

хороололд амьдарч байсан байна.

ОУВС-гийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд Засгийн газартай тохирсны дагуу Ипотекийн зээлийн хөтөлбөрийг 2019 оны нэгдүгээр сарын 1-нээс Засгийн газарт шилжүүлнэ. Тиймээс хөтөлбөрийг шилжүүлэх төлөвлөгөөг Монголбанк ирэх есдүгээр сард багтаан батлах бөгөөд орсон өөрчлөлтүүдийг мэдээлэх юм байна. Мөн энэ төслийн хэрэгжилтийн чиглэлээр Монголбанк арилжааны банкуудад энэ ондоо багтаан шалгалт хийхээр төлөвлөсөн гэж байгаа. Ипотекийн зээлийн хүрээнд энэ оны долоодугаар сард 629 иргэнд 46.9 тэрбум төгрөгийн зээл олгожээ. Үүнээс 6.3 тэрбум төгрөгийн зээлийг орон нутгийн 167 иргэн авсан байна. Сүүлийн үед банкуудын өөрийн эх үүсвэрээр олгож байгаа ипотекийн зээлийн хэмжээ нэмэгдэж байгаа нь эерэг үзүүлэлт гэж Монголбанк мэдээлсэн.

Бага орлоготой хүмүүс өөрсдийн чадлын хэмжээгээр явах зүйлийг банкууд орж ирж барилгын үнийг өсгөөд, хамгийн сүүлд нь энэ төсөл нь удаан явахгүй болохоор одоо төсөв рүү шилжиж байгаа нь энэ. Тэгээд үүний үнийн зөрүүг татвар төлөгч та бид л төлчихөж байгаа юм. Сингапур зэрэг орон эхлээд бага талбайтай байраар бүх айлаа орон сууцжуулаад, эдийн засаг нь өсөхийн хэрээр байраа томруулаад явдаг. Ерөөс байр авч чадахгүй хүмүүстээ түрээсийн байр олноор нь бий болгож өгдөг ба энэ чиглэлийг л барих нь зөв гэж бодож байна. Ийм замаар явбал хүн худалдаж авахгүй үнэтэй байрнууд тэртээ тэргүй хямдарчихна. Энэ хооронд хэдэн компани л дампуурна байх. Бүгдээрээ дампуурснаас дээр биз дээ.

340 МЯНГАН ТОНН НҮҮРС ХААЧИВ?

УИХ-ын гишүүн Л.Энхболд “Эрдэнэс Тавантолгой” компанийн эзэмшлийн талбайгаас 268.3 мянган тонн нүүрс хулгайд алдагдсан талаар өмнө нь мэдээлэл хийж байсан. Тлэгвэл мэргэжлийн байгууллагын шалгалтаар тус талбайгаас 340 мянган тонн нүүрс алга болсон нь тогтоогдсон байна.

Засгийн газар үүрэг өгөөд, энэ асуудлыг 10 агентлаг хамтарсан Сангийн сайд Ч.Хүрэлбаатараар ахлуулсан ажлын хэсэг байгуулж шалгасан юм байна. Шалгалтын явцад Гаалийн ерөнхий газраас гаргасан дүгнэлтийн хүрээнд МУ-ын гаалиар эх үүсвэргүйгээр 390 мянган тонн нүүрс Тавантолгойн орд газраас гарсан байна гэсэн дүгнэлт хийсэн байгаа юм. Мөн Хил хамгаалах газраас 2013-аас 17 оны хоорондурд хилээр 849 мянган машин хил гарсан гэсэн ба Гаалийн ерөнхий газраас 814 мянган машин гарсан гэсэн мэдээ өгсөн байна. Энэ 2-ын хооронд 35 мянган машины зөрүү гараад байгаа ба хил гааль 2 чинь яаж тоолохоороо 35 мянган машины зөрүү гаргаад байгаа юм бэ?

Энэ бол зүгээр л Тавантолгойн асуудал бус бид нарын хөрөнгө. Хил гааль дээр ажлаа хийж байгаа хүн байна уу. Гаалийн шалгалтаар Тавантолгой гэж орон нутгийн хувьцаат компанийн бүх

нүүрсийг ганцхан компани зөөдөг бөгөөд түүнийг нь Тавантолгой Транс компани гэдэг. Ийм олон мянган тонн нүүрсийг энэ компани эх үүсвэр нь мэдэгдэхгүй хил нэвтрүүлээд байдаг ямар учиртай юм бэ? Энэ компани нь Тавантолгой ХК-ийн гэрээт тээвэрлэгч бөгөөд Ажнай корпорацийн охин компани юм байна. Ажнай корпорацийн эзэн нь Батлан хамгаалахын сайд асан, УИХ-ын гишүүн асан Д.Бат-эрдэнэ. Тавантолгой ХК-ын 51 хувь нь орон нутгийн өмч, 49 хувийг нь олон жижиг хувьцаа эзэмшигч эзэмшдэг бөгөөд үүнээс хамгийн том хувьцаа эзэмшигч нь Ажнай корпораци. Энэ ХК-ийн тайланг үзэх гэсэн ч 2017 оны тайлан нь байхгүй байна лээ. Санхүүгийн зохицуулах хороо нь тэгвэл хаана байгаа юм бэ? 1900 хүн эзэмшдэг энэ ХК-ийн 2017 оны мэдээлэл яагаад юу ч байхгүй байгаа юм бэ?

Энэ 340 мянган тонн нүүрс Тавантолгойн санхүүгийн баланс дээр туссан уу, үгүй юу?


БНХАУ-ЫН ГАДААД ХЭРГИЙН САЙДЫН АЙЛЧЛАЛ

Монгол Улсын Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатарын урилгаар БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн гишүүн, Гадаад хэргийн сайд Ван И 2018 оны 8 дугаар сарын 23-25-ны өдрүүдэд Монгол Улсад албан ёсны айлчлал хийсэн. Тэрээр энэ удаагийн айлчлал нь Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн БНХАУ-д хийсэн албан ёсны айлчлалын хүрээнд талуудын хүрсэн зарчмын тохиролцоог ажил хэрэг болгох зорилготой гэдгийг онцлоод хоёр талын эдийн засгийн хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн хөгжүүлэхэд бэлэн байгаагаа илэрхийлсэн. Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Их хурлын дарга нарт бараалхсан. Айлчлалынхаа хүрээнд БНХАУ-ын Төрийн зөвлөлийн гишүүн бөгөөд Гадаад хэргийн сайд Ван И Увс аймагт ажиллаж, баруун бүсийн 5 аймгийн (Увс, Завхан, Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай) удирдлагатай уулзаж санал солилцсон.

Урдхөршийн гадаад хэргийн сайд бол Хятадулсын төрийн зөвлөлийн гишүүн. Манайхны хэлдгээр давхар дээлтэй. Удалгүй манай удирдлагууд Хятад руу явж ажиллана. Тэгэхээр 2 улсын Ерөнхийлөгч уулзана. МУ-ын баруун 5 аймаг болох Баян-Өлгий, Ховд, Увс, Говь-Алтай, Завханд нийлээд 400 мянган хүн амьдарч байгаа. Энэ хүмүүсийн ажил амьжиргааны түвшин урд хилээс нэлээд хамааралтай болсон. Манай наймаачид бараагаа аваад очихоор хил гаргахад хэцүү, орсон хойноо янз бүрийн юу нь мэдэгдэхгүй тариф тогтоогоод байдаг гэдэг гомдол маш их ирсний дагуу энэ сайдыг ирэхэд нь тухайн орон нутгийн хүмүүстэй нь уулзуулсан юм байна. МУ-д гадаад худалдааны яам гэж байхгүй.

МУ-ын гадаад худалдааг гадаад харилцааны яам хариуцдаг буюу яаманд гадаад худалдааны бодлогын газар гэж байгаа. Тэгэхээр Д.Цогтбаатар сайд бол гадаад харилцаанаас гадна гадаад худалдааг хариуцсан сайд юм.

Төрийн зөвлөлийн гишүүн, Гадаад хэргийн сайд Ван И айлчлалынхаа хүрээнд БНХАУ-ын Засгийн газрын буцалтүй тусламжаар баригдаж буй Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн



төвийн барилгын явц, “Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудлын шалган нэвтрүүлэх хэсэг дэх “Бүс ба Зам-зорчих нөхцлийг хөнгөвчлөх” санаачлагын хүрээнд байгуулсан тусгай гарцтай тус тус танилцаж, БНХАУ-ын Засгийн газрыг төлөөлж Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн хамт “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг барих төсөл”-ийн бүтээн байгуулалтын нээлтийн ёслолд оролцсон.



NEW NISSAN PATROL

ЛИЗИНГИЙН НӨХЦӨЛ:

Урьдчилгаа **0 %**

Хүү **1.4 %**

Хугацаа **84 сар**

УРАМШУУЛАЛ:

Хамгаалалтын хууца

Сансбар сервисын эрх


4ш Өвлийн дугуй

Салонины шалны хамгаалалт

ҮНЭ: ₮214.0 сая

☎ 9911-0014, 9911-5140, 9910-0167

*Дефакто тоймын гол агуулгыг
хураангуйлан бэлтгэв
Тоймын бүрэн эхийг
jargaldefacto.com вебсайтаас
үзэх боломжтой.*



JARGAL DEFACTO

ГАР УТАСНЫ АППЛИКЭЙШН

The Defacto Gazette

➤ АНГЛИ

➤ МОНГОЛ

➤ ЯПОН



GOOGLE STORE

APP STORE



Та “Дефакто Газет” цахим сонинг төлбөргүй тогтмол хүлээн авахыг хүсвэл
www.jargaldefacto.com болон www.defacto.mn вебсайтад өөрийн имейлээ бүртгүүлнэ үү.

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Ерөнхий эрхлэгч:
 Дамбадаржаагийн Жаргалсайхан

Ерөнхий Редактор:
 Ганбаатарын Жавзмаа

ГҮЙЦЭТГЭЛИЙН БАГ

Отгонсүрэнгийн Билгүүн
 Адъяагийн Тунгалаг

ХОЛБОО БАРИХ

✉ editor1@jargaldefacto.com

☎ +976 94109342

🌐 www.defacto.mn

www.jargaldefacto.com